



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.07.16-07.19

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Хоёр дугаар улирлын санхүүгийн тайлан гарах үе тохиож байгаатай холбоотойгоор АНУ-ын голлох индексүүд бага хэмжээгээр унаж хаагдлаа.

S&P 500 индексийн сагсанд багтаж буй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон түүхий эд боловсруулагч компаниудын хувьцааны ханш өссөн бол эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна. АНУ-ын газрын тосны нийлүүлэлт урьдчилан таамаг төвшнөөс бага хэмжээгээр буурснаар газрын тосны ханш буурчээ.

"Netflix" компанийн АНУ дахь хэрэглэгчдийн тоо буурч, харин олон улс дахь харилцагчдын тоо таамаг хэмжээнд хүртлээ өсөж чадаагүй учраас тус компанийн хувьцаа унасан байна.

Ройтерс болон FactSet агентлагууд хувьцаат компаниудын 2019 оны 2-р улирлын ашгийн үзүүлэлт өмнөх оны мөн үетэй ойролцоо байна хэмээн үзэж байна.

АНУ-н Холбооны нөөцийн сан энэ сарын 30-31-ний өдрүүдэд болох Мөнгөний бодлогын хуралдаанаар бодлогын хүүгээ 0.25 эсвэл 0.50 хувиар бууруулах эсэх нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байна.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал даамжирч, Европын бүсийн хувьцааны зах зээлд сөргөөр нөлөөлөв. АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп БНХАУ-ын 325 тэрбум ам.доллартой тэнцэх экспортын бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулна хэмээн мэдэгдэж, хоёр улсын худалдааны хэлэлцээр зогсонги байдалд оржээ.

Их Британи Европын холбооноос ямар нэгэн хэлэлцээргүй гарч, мөн тус улсын дараагийн Ерөнхий сайдаар Борис Жонсон сонгогдох магадлал өсөж байгаатай холбоотойгоор фунгийн ханш сулран, сүүлийн 2 жилийн хамгийн доод төвшинд хүрлээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс буурч хаагдлаа.

6-р сард Япон улсын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар буурсан нь эдийн засагчдын таамаглаж байсан хэмжээнээс өндөр байв. Ингэснээр тус улсын экспорт 7 сар дараалан унаж байгаа ажээ. Экспортын хэмжээ буурах болсон гол шалтгаан нь АНУ, Хятад улс хоорондын худалдааны маргаанаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн удаашрал юм.

Япон улсын Сангийн яамны мэдээлснээр энэ оны эхний хагас жилийн байдлаар Хятад улс руу хийсэн экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурчээ. Харин Хятад улсаас Япон улс руу орж ирсэн импортын хэмжээ 0.1% өсөж, тус улстай хийсэн төлбөрийн тэнцлийн алдагдал 2.05 их наяд иен болов.

БНХАУ: 2019 оны 2-р улиралд БНХАУ-ын ДНБ өмнөх оны мөн үеэс 6.2%-аар өсөж, 1992 оноос хойших хамгийн бага өсөлтийг үзүүлээ. БНХАУ-ын эрх баригчид эдийн засгийг өсөлтийг дэмжих бодлогыг эрчимтэй явуулж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,612.23	-0.51% ▼
Dow Jones	АНУ	27,154.20	-0.65% ▼
S&P 500	АНУ	2,976.61	-1.23% ▼
Nasdaq	АНУ	8,146.49	-1.18% ▼
S&P/TSX	Канад	16,485.94	-0.01% ▼
FTSE 100	Их Британи	7,508.70	0.04% ▲
S&P/ASX 200	Австрали	6,704.50	0.77% ▲
Nikkei 225	Япон	21,466.99	-1.01% ▼
Hang Seng	Хонг Конг	28,765.40	0.74% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.35
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.95
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.98
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.92
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.87
DBM' 2023	USD	7.250%	104.77
TDBM' 2020	USD	9.375%	103.36

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.260	-0.07 ▼
Libor 3M	2.260	-0.06 ▼
Libor 6M	2.140	-0.09 ▼
Libor 1YR	2.160	-0.07 ▼
US 2YR Bond	1.819	-0.02 ▼
US 3YR Bond	1.782	-0.03 ▼
US 5YR Bond	1.808	-0.05 ▼
US 10YR Bond	2.043	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.07.19	Өөрчлөлт
USD	2,661.76	0.08% ▲
CNY	387.22	0.24% ▲
EUR	2,998.21	0.53% ▲
RUB	42.32	1.51% ▲
KRW	2.27	0.89% ▲
JPY	24.73	1.31% ▲
CAD	2,042.32	0.85% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,425.37	0.68% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	16.20	6.44% ▲
Зэс	USD/lb.	275.25	2.17% ▲
Нүүрс	USD/MT	75.58	0.20% ▲
WTI газрын тос	USD/bbl.	55.63	-7.61% ▼
Brent газрын тос	USD/bbl.	62.47	-6.37% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.25	-8.16% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. V	11.03%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. V	11.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. V	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. V	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. V	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 239.0 сая төгрөгийн 1,625,660 ширхэг хувьцаа арилжигдав.

“Женко тур бюро” /JTB/ компанийн хувьцаа 14.74%-аар буюу хамгийн ихээр өсөж 70 төгрөгт хүрч хаагдсан бол “Бөхөг” /BHG/ компанийн хувьцаа 11.11%-аар буурч 2,200 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

7-р сарын 19-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,580.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,612.23 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.51%-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	239.0
Зах зээлийн үнэлгээ	2,580,384.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,612.23	-0.51% ▼
MSE I индекс	9,602.97	-0.81% ▼
MSE II индекс	8,186.61	0.80% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард кредит ББСБ	1,140,535	91,033,957
Инвескор ББСБ	20,937	36,207,754
Говь	87,063	25,392,917
АПУ	42,182	23,954,168
Монгол базальт	45,723	14,533,403

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Женко тур бюро	70.00	14.74% ▲
УБ-БҮК	399.00	10.22% ▲
Жуулчин дютти фрий	108,800.00	7.72% ▲
Ард кредит ББСБ	79.90	1.14% ▲
Апу	572.00	0.17% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Бөхөг	2,200.00	-11.11% ▼
Улсын их дэлгүүр	501.00	-6.36% ▼
Монгол шуудан	595.00	-5.56% ▼
Бэрх Уул	500.00	-4.76% ▼
Гермес центр	120.00	-4.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	121,978,972
Зэргэд	87,220,173
Голомт Капитал	66,549,317
БиДиСек	50,279,130
Инвескор Капитал	35,512,734

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	572.00	608,712
Таван толгой	7,165.00	377,346
МИК Холдинг	14,500.00	300,285
Говь	291.33	227,270
Инвескор ББСБ	1,764.00	126,528

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эм дабльдью ти эс ҮЦК” ХХК болон “Фронтierer ҮЦК” ХХК-ийг МХБ-ийн гишүүнчлэлээс хаслаа

СЗХ-ны 2017 оны 9-р сарын 27-ны өдрийн 168 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Эм Дабльдью Ти Эс ҮЦК” ХХК, СЗХ-ны 2019 оны 4-р сарын 24-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор мөн тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Фронтierer ҮЦК” ХХК-ийг МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 28-ны өдрийн 2019/05 болон 2019/06 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлээс тус тус хаслаа.

“Эм Дабльдью Ти Эс ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг СЗХ-ны 2018 оны 4-р сарын 04-ний өдрийн хуралдаанаар МХБ-ийн гишүүн “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлж, нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжийг бүрдүүлсэн билээ. Харин “Фронтierer ҮЦК” ХХК-ийн харилцагчийг шилжүүлэх тендер одоогоор зарлагдаагүй байгаа бөгөөд тендер зарлагдаж, СЗХ-ны холбогдох шийдвэр гарсны дараа тус компанийн харилцагчдад МХБ-ийн цахим хуудсаар шийдвэрийн тухай мэдэгдэх болно.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Улсын их дэлгүүр: 169.2 Сая төгрөгийн ашигтай ажиллав

Үл хөдлөх хөрөнгөө түрээслэн орлого олж буй Улсын их дэлгүүр /MSE:UID/ компани 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа танилцуулав.

Тайлант хугацаанд компани 2.7 тэрбум төгрөгийн орлого олж, нэгж хувьцаандаа EPS = 4.6 төгрөг буюу нийт 169.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хамгийн сүүлд тус компанийг “Номин реалтор” ХХК-тай түрээсийн гэрээ байгуулахдаа зах зээлийн үнээс хэт багаар гэрээ байгуулж, компанийг алдагдалд оруулан, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчиж байгаа талаар СЗХ-ноос тогтоосон билээ. Үүнтэй холбоотойгоор СЗХ цаашид ямар арга хэмжээ авахыг хүлээх үлдлээ. Компанийн хувьцааны ханшийн тухайд нэгж хувьцааны үнэ 501 төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд тус компанийн хувьцаа сүүлийн хэдэн жил ханшаа тогтвортой хадгалж байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn



АПУ: 2019 оны хагас жилийн ашиг 33%-аар буурчээ

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд 2019 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгээ танилцуулж эхлээд байгаа.

АПУ /MSE:APU/ компанийн хувьд энэ оны эхний хагас жилд 102.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 9.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, тус компанийн борлуулалтын орлого 2.82 тэрбум төгрөгөөр буюу 2.83%-аар өссөн боловч ашигт ажиллагаа 33%-аар буурлаа. Компанийн ашиг буурахад тус компанийн ерөнхий ба удирдлагын зардал 12.3 тэрбум төгрөг буюу 122%-аар өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ. 2017 оны эхний хагас жилд гадаад валютын ханшийн зөрүүнээс 851.4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байсан бол энэ онд тус алдагдал 23.8 сая төгрөг болж буурсан нь онцлог үзүүлэлт боллоо. Энэ нь АПУ хувьцаат компани олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлээ өнгөрөгч онд төлж барагдуулсантай холбоотой аж.

Энэхүү хагас жилийн тайлан нь охин компаниудын санхүүгийн үзүүлэлтийг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлан биш гэдгийг дурьдах нь зүйтэй.

Хувьцааны ханшийн тухайд 2019 7-р сарын 19-ний өдрийн байдлаар “АПУ” ХК-ийн хувьцааны ханш 572 төгрөг байгаа нь энэ оны эхнээс 50.11 төгрөг буюу 8.1%-аар буурсан үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо анх удаа 6,000 давсан нь хөрөнгө оруулагчид тус компанид итгэх итгэл нэмэгдсэн гэдгийг батлав.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Талын гал” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Талын гал” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 45 төгрөг (татварын дараах) хуваарилсныг 2019 оны 7-р сарын 19-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

МИК Холдинг” ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөгджээ

Улаанбаатар банкны зүгээс “МИК Холдинг” /MSE:MIK/ компани дахь эзэмшлээ бууруулсаар байна. 2018 оны эцсээр Улаанбаатар банк “МИК Холдинг” компанийн 17.1%-ийг эзэмшдэг байсан бол энэ 7-р сарын эхээр 2 удаагийн багцын арилжаагаар өөрийн эзэмшлийн 4.5%-ийг нийт 14.3 тэрбум төгрөгөөр худалджээ. Харин “Азиа дайверсифайд рийл истейд фонд нэг” ХХК нь “МИК Холдинг” ХК-ийн эзэмшил хувиа 11.2% болгон нэмэгдүүлэв.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Мон-Ит Булигаар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болж өнгөрлөө

“Мон-Ит Булигаар” /MSE:MBG/ компанийн том хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, тус компани шинэ стратегийн хөрөнгө оруулагчтай болсонтой холбоотойгоор 7-р сарын 20-ий өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хуралдуулжээ. Тус хурлаар компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн ийг өөрчлөн, хувьцаа хуваах асуудлыг хэлэлцсэн баталсан байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 6-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 6 дугаар сарын эцэст 20.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 67.1 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 (16.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 6 дугаар сарын эцэст 937.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.6 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 6.0 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 237.1 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.8 (18.3%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 6 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.5 (1.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 596.9 (45.3%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 6 дугаар сард 2 654.47 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар тус тус суларсан байна. Харин төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 6 дугаар сард 384.62 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар суларч, өмнөх сараас 0.3 хувиар чангарсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.9 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.7 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 192.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 6 дугаар сард 948.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 128.6 (15.7%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 902.4 тэрбум төгрөгт хүрч, 57.9 (6.0%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.1 хувийг татварын орлого, 8.2 хувийг татварын бус орлого, 11.1 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 583.1 (14.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 412.8 (11.6%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 240.9 (61.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 84.2 хувь, хөрөнгийн зардал 13.5 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.3 хувийг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 410.0 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 156.0 сая америк доллараар өсжээ.

Урсгал данс 444.1 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 810.5 сая америк доллар, анхдагч орлогын данс 509.8 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 5 сард 34.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 3.7 (12.0%) сая америк доллараар өссөн байна.

Харин санхүүгийн дансны тэнцэл 646.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.8 (1.3%) сая америк доллараар буурчээ.

Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 5 сард 233.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 31.8 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2019 оны эхний хагас жилд дэлхийн 137 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6.8 тэрбум америк доллар, үүнээс экспорт 3.9 тэрбум америк доллар, импорт 2.9 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2019 оны 6 дугаар сард экспорт 675.6 сая америк долларт, импорт 578.7 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 75.8 сая америк доллараар буурч, импорт 29.9 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний хагас жилд 822.2 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2019 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 223.0 сая америк доллараар өсөж, 1.0 тэрбум америк долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 оны 6 дугаар сард 96.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 105.7 сая америк доллараар буурсан байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 4.9 хувь, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 4.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.